МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 06 өдөр Дугаар А/570 Мөрөн сум

Захирамжийн хавсралтад нэмэлт
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4, 4.2.5, 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/126 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 4 дэх мөрөнд "Арга хэмжээний нэр" гэсэн хэсгийн "Тариалан суманд баригдах 22 ортой эрүүл мэндийн төвийн барилгын гадна дулааны шугамын өргөтгөл, халаалтын тогоо болон нэмэлт насос суурилуулах ажлын зураг төсөл боловсруулах" зөвлөх үйлчилгээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр баригдах 22 ортой эрүүл мэндийн төвийн барилгын зураг төсөвт оруулан тооцсон байх тул тус мөрийг хассугай.

2. Дээрх зөвлөх үйлчилгээнд зарцуулахаар төлөвлөсөн 12,000,000 (Арван хоёр сая) төгрөгийг доорх зөвлөх үйлчилгээнүүдийн санхүүжилтэд зарцуулсугай. Үүнд:

2.1. "Мөрөн сумын хог хаягдлын цэг дэх ажилтны амрах байрны барилгын ажлын зураг төсөл боловсруулах" төсөвт өртөг 8,000,000 (Найман сая) төгрөг

2.2. "Мөрөн сумын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид автомат усжуулалтын систем суурилуулах ажлын зураг төсөл боловсруулах" төсөвт өртөг 4,000,000 (Дөрөвөн сая) төгрөг.

3. Дээрх өөрчлөлт орсон төсөл арга хэмжээний зураг, төсвийг боловсруулах зөвлөх үйлчилгээ нийлүүлэх гүйцэтгэгч сонгож гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангуулах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог), сумын Засаг дарга, агентлаг байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

4. Төсөл арга хэмжээний зураг төсвийн үнийг заагдсан эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т тус тус даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирам.к-2023

6712011295